



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/18

Мандалговь

Музейн хүрлийн үеийн үзмэрийг
шинжлэн, судлах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хүрлийн үеийн үзмэрийг шинжлэн судлах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Амартүвшин(ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор)

Гишүүд:

Ж.Оюунцэцэг(ШУА-ын Хими, Химийн технологийн хүрээлэн, материал судлал, технологийн лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх зэргийн ажилтан доктор (Ph.D))

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэбаатар(УБИС-ийн Археологийн тэнхмийн эрхлэгч, доктор (Ph.D) профессор)
Ж.Баярсайхан(Монголын үндэсний музейн Эрдэм шинжилгээний төвийн дарга, доктор)
Г.Анхсанаа(Соёлын өвийн үндэсний төвийн мэргэжилтэн)

Хоёр. Үзмэр шинжлэн, судлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Ч.Амартүвшин)-т даалгасугай.

Гурав. Шинжлэн, судалсан ажлын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлэхийг ажлын хэсэг (Ч.Амартүвшин)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010044